

**ӨВӨР МОНГОЛЫН ӨӨРТӨӨ ЗАСАХ ОРНООС ӨРНҮҮЛСЭН ШИНЭ
МОНГОЛ ҮСГИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ (1947-1958)
ТУХАЙ ШИНЖИЛГЭЭ**

БАЙ ЛИН

*Өвөр монголын Багшийн Их сургуулийн
Түүхийн тэнхимийн багш, доктор (Ph.D)*

Агуулгын товч: 1947-1958 онд БНХАУ-ын ХКН-ын Төв Хорооноос явуулсан төрийн бодлогын хүрээнд цөөн тоот үндэстний соёлын түвшнийг нийтэд нь дээшлүүлэх, улсын дотоод дахь аж ахуйн хөгжлийн хурдтай зохицохын тулд 1947 онд Өвөр Монголын Өөртөө Засах Орноос соёлыг дээшлүүлэх хөдөлгөөнийг өрнүүлсэн. Хуучин монгол үсэгт өөрчлөлт хийж слав галиг бүхий шинэ монгол үсэг (кирилл үсэг) хэрэглэхээр туршсан байна. БНХАУ байгуулагдсаны дараа ХКН-ын Төв Хорооноос улсын хэмжээнд болон 1955 оноос ӨМӨЗО-ны Засгийн ордноос шинэ монгол үсгийн өөрчлөлтийг хэрэгжүүлэхээр шийдэв.

Хэдийгээр Өвөр монгол дахь шинэ монгол үсгийн өөрчлөлтийг ЗХУ, БНМАУ (хуучнаар)-аас дэмжиж байсан боловч “Зөв бичгийн дүрэм” болон “Галиг үсэгт засвар оруулах” тал дээр зөрчилтэй байсан юм. Үүгээр үл барам БНХАУ, ЗХУ-ын харилцааны нөлөө болон ХКН-ын Төв Хорооноос хэрэгжүүлсэн латин галигт суурилсан “Хятад хэлний галиг үсэг”-г өөрчлөлт хийх мэдэгдлээс шалтгаалан, 1958 онд ӨМӨЗО-ны Засгийн ордноос шинэ монгол үсгийн (кирилл үсэг) өөрчлөлтийг зогсоожээ. ӨМӨЗО-ноос өрнүүлсэн шинэ монгол үсгийн өөрчлөлт нь БНХАУ-ын ХКН-ын Төв Хорооноос цөөн тоот үндэстэн бүхий газар орны соёл ба боловсролын түвшнийг дээшлүүлэх гэсэн оролдлого, мөн БНХАУ-аас гадаадад хандуулах төрийн бодлогоо баяжуулсны нэг илрэл байсан юм.

Түлхүүр үг: ӨМӨЗО (Өвөр Монголын Өөртөө Засах Орон), шинэ монгол үсэг, үсэг бичгийн өөрчлөлт, БНХАУ (Бүгд Найрамдах Хятад Ард Улс), ХКН (Хятадын Коммунист нам), Бүгд Найрамдах Монгол Ард Улс (БНМАУ), Зөвлөлт Холбоот Улс (ЗХУ).

Үсэг бичгийн өөрчлөлт бол шинээр байгуулагдсан БНХАУ-ын нийгэм, аж ахуй, соёлын бүтээн байгуулалтад хамаатай чухал асуудлын нэг байж, БНХАУ байгуулагдсаны дараа улсын хэмжээнд үсэг бичгийн өөрчлөлт болон хятад үсгийг дөхөмчлөх хөдөлгөөнийг өрнүүлжээ. ӨМӨЗО-ны Засгийн ордон эрт байгуулагдсаны хувьд БНХАУ-ын ХКН-ын Төв Хорооны удирдлага дор 1947

оноос эхлэн шинэ монгол үсгийн (кирилл үсэг) өөрчлөлтийн хөдөлгөөнийг туршжээ. Энэ хугацаанд ӨМӨЗО-ны намын ажилтан болон сургуулийн сурагчид гэх мэт нийтдээ зуун мянгаас илүү хүн үсэг бичгийн өөрчлөлтөд оролцож шинэ монгол үсэгт (кирилл үсэг) суралцсан байна.

БНХАУ-ын эрдэм шинжилгээний болон бусад байгууллагууд нэлээн судалсан боловч тэдгээр өгүүлэл нь голдуу үндэстний хэл, утга зохиол, үсэг бичгийн тухай төрийн бодлогын үүднээс ярьсан буюу шинэ монгол үсгийн өөрчлөлтийн тухай дөхөмхөн тэмдэглэснээс биш шинэ монгол үсгийн өөрчлөлтийн орчин, нөхцөл явц ба БНХАУ-ын ХКН-ын Төв Хорооноос явуулсан үсэг бичгийн өөрчлөлтийн бодлого, түүхийн үүднээс гүнзгий судалгаа хийгдээгүй юм.¹

Энэхүү байдалд үндэслэн зохиогчоос сүүлийн жилүүдэд цуглуулсан БНХАУ-ын Гадаад харилцааны яамны архивын баримт, Өвөр монголын Өөртөө Засах Орны архивын баримт болон Монгол Улсын архивын баримт зэргийг ашиглахын хамт нэгэнт хэвлэгдсэн холбогдол бүхий эх бичиг, сонин, сэтгүүл, судалгааны бүтээл зэрэгт түшиглэн БНХАУ-ын үсэг бичгийн өөрчлөлтийн орчин нөхцөлд ӨМӨЗО дахь шинэ монгол үсгийн өөрчлөлтийн хөдөлгөөний тухай судалгаа хийж, тус асуудлын үндсэн байдал, төрийн бодлогын өөрчлөлтийн тухай бүхий л баримтаас нягтлан үзэв.²

Нэг. ӨМӨЗО дахь шинэ монгол үсгийн өөрчлөлтийн нөхцөл байдал

ӨМӨЗО дахь шинэ монгол үсгийн өөрчлөлтийн хөдөлгөөн нь БНХАУ байгуулагдсаны дараах дотоод, гадаад төрийн бодлоготой нягт холбоотой. БНХАУ-ын ХКН-ын Төв Хорооноос хэрэгжүүлсэн үндэстний төрийн бодлогын үр дүн болохын сацуу ӨМӨЗО-ны соёл, аж ахуйн байгуулалтын хөгжлийн үндэс болсон. Үүний хамт ӨМӨЗО дахь шинэ монгол үсгийн өөрчлөлт БНХАУ, БНМАУ хоёр улсын харилцаанд сайнаар нөлөөлжээ.

БНХАУ байгуулагдсан эхэн үед урт хугацааны дайн дажны үймээнээс болж улсын аж ахуй, соёл уналтад орж, хөгжил туйлын дорой байв. Цөөн тоот үндэстнүүдийн харилцааг чангатгаж, түүний аж ахуйг хөгжүүлэх, соёлын түвшнийг дээшлүүлэхийн тулд 1949 оны 9 дүгээр сард БНХАУ-ын Ардын улс төрийн зөвлөгөөний хуралдаанаар баталсан “Хамтын хөтөлбөр”-г эл цөөн тоот үндэстэн бүр хэл, үсэг бичгээ хөгжүүлэх эрх чөлөөтэй” гэжээ.³ БНХАУ

¹ Хичээлт, С. “Улаанхүүгийн үндэстний хэл бичгийн төрийн бодлогыг туушуулах арга барил тогтолцооны тухай өгүүлэх нь”, Өвөр Монголын Их Сургуулийн сэтгүүл, 2011, 2. Хичээлт, С. “Нийгмийн үг хэлний судлал үг хэлний төрийн бодлого”, ӨМӨЗО-ны Ардын Хэвлэлийн Хороо, 1997. Түмэнжаргал “Монгол үг хэлийг суралцаж ашиглах болон судлах тухай асуудал”, Өвөр монголын Сурган Хүмүүжлийн Хэвлэлийн Хороо, 2008. Намжил, Ш. “Үг хэл болон үндэстний оюун билиг нийгмийн эе зохицлын тухай”, Өвөр монголын Шинжилгээ техникийн хэвлэлийн хороо, 2006 он.

² Тус өгүүлэлд шинэ монгол үсэг (бас кирилл үсэг буюу слав монгол үсэг гэдэг, Монгол Улсад одоо хэрэглэгдэж буй). Хуучин монгол үсэг гэгч нь Өвөр Монголын Өөртөө Засах Оронд хэрэглэгдэж байгаа уйгур монгол үсэг буюу хуучин монгол үсэг гэж ойлгоно.

³ Дундад улсын ардын улс төрийн зөвлөгөөний хуралдааны нэгдүгээр хугацааны бүгд хуралдаан: Хамтын хөтөлбөрийн VI бүлгийн 53 дугаар зурвасын тогтоол, цөөн тоот үндэстэн нэг бүр өөрийн үг хэл үсэг бичгийн талаарх зан заншил, шашин шүтлэгээ хөгжүүлэх, баримтлах буюу өөрчлөх эрх чөлөөтэй. Эл цөөн тоот үндэстний олон түмний улс төр, аж ахуй, соёл, сурган хүмүүжлээ бүтээн байгуулах үйлсэд ардын засгийн ордноос дэмжих ёстой. Ардын хэвлэлийн хороо, 1952, Дундад улсын ардын улс төрийн зөвлөгөөний хуралдааны хамтын хуулбар 17 дугаар нүүр.

байгуулагдсан эхэн үеэс аж үйлдвэржсэн улсыг бүтээн байгуулах, орчин үечүүлэх болон тариалангийн хоршоолол ба механикжилд зэргээс нэн тэргүүнд соёл, боловсролын түвшнээ дээшлүүлэх шаардлагатай байв.

БНХАУ-ын цөөн тоот үндэстнүүдийн нөхцөл байдал хөгжлөөр туйлын дорой, эрт байгуулагдсан ӨМӨЗО нь урт хугацааны Японы түрэмгийлэл, дайн дажны нөлөөнөөс болж, аж ахуй туйлын доройтож, соёлын хөгжил маш хоцрогдонгуй байсан бөгөөд тухайн үед Өвөр монголын соёл болон бичиг үсгийн тайлагдалт хүн амын 10 орчим хувийг эзэлж байв.⁴

БНХАУ байгуулагдсаны дараа авч хэрэгжүүлсэн аж ахуй болон соёл, үндэстний хэл бичгийн шинэчлэлийг хийхдээ 1951 он гэхэд Хятад даяар 843 бага сургууль байснаас 3774, дунд сургууль 9 байснаас 12 болж нэмэгджээ.⁵ 1955 он болоход сургуульд байгаа монгол сурагчид 10000-90000 болон өссөн байна.⁶

ӨМӨЗО-ны албан байгууллагуудаас олон зүйлийн монгол ном хэвлэсэн нь нийт 600 гаруй төрлийн 5 сая гаруй дэвтэр, монгол сонин, сэтгүүл нь арваад төрөл байх боловч ӨМӨЗО-ны соёл, аж ахуйн хэрэгцээг хангаж чадахгүй болохоор өөртөө засах орон байгуулагдсанаас эхлэн хуучин монгол үсэгт өөрчлөлт хийхээр болсон байна.

“Хэлбэрийг нь дуурайж зурах” аргаар монголын кирилл үсэгт үндэслэсэн шинэ монгол үсгийг шууд ишилж хэрэглэсэн байна. Монгол болон Өвөр монгол нь угсаа нэгтэй учраас монгол хэл ба хуучин монгол үсгийг хамтдаа хэрэглэж байсан юм. Хэдийгээр тухайн үед Монголд нэгэнт шинэ үсэг хэрэглэх болсон боловч үндсэн үгс, хэл зүй зэргийн талаар үндсэндээ адил байдаг болохоор, Өвөр монголын олон түмэн шинэ монгол үсгийг сурч хэрэглэхэд ашигтай байсны хамт монголын тэргүүний мэргэжил, төхөөрөмжийг шууд оруулах ба эзэмшиж болохоос гадна хуучин монгол үсгийг жагсааж бичих зэрэгт их хэмжээний цагийг хэмнэж байв.

Нөгөө талаар ЗХУ болон БНМАУ дахь үсэг бичгийн өөрчлөлтийн талаарх амжилт нь ӨМӨЗО-д шинэ монгол үсгийн хэрэглээг түргэтгэж, ардын соёл, боловсролын түвшнийг дээшлүүлэх гэсэн шаардлагад нийцэж байсны хамт, улсын бүтээн байгуулалтын зэрэгт шинэ монгол үсгийн өөрчлөлтийг өрнүүлэх эхлэлийг тавьжээ.

1921 онд Бүх Оросын Коммунист (Большевик) Намаас цөөн тоот үндэстнүүд өөрийн хэл, үсэг бичгээ хэрэглэх гэсэн төрийн бодлогыг зарласнаас гадна (буриад болон халимаг, монголыг хамарна) кирилл үсэгт суурилсан шинэ монгол үсгийн өөрчлөлтийг хийсэн. Удалгүй ЗХУ-аас БНМАУ-ын улс төр, аж ахуй болон соёлыг бүх талаар хөгжүүлэхийн тулд хуучин монгол үсгийг кирилл үсэгт суурилсан шинэ монгол үсгээр өөрчилж эхэлжээ. 1946 онд шинэ монгол үсгийг монголд бүх талаар хэрэгжүүлснээр ард олны соёлын дундаж түвшин зохих хэмжээгээр дээшилсэн байна. Энэ нь шинэ монгол үсгийн онцлог (ярианы хэл болон үсэг нэгдэлтэй, үсгийн хэлбэрийн хувирал байхгүй, хөндлөнгөөр бичиж болох, цагаан

⁴ 《在毛主席的民族政策照耀下，内蒙古人民胜利前进—内蒙古自治区人民政府成立五年来的辉煌成就》，《人民日报》第3版，1952年6月9日。

⁵ 《在毛主席的民族政策照耀下，内蒙古人民胜利前进—内蒙古自治区人民政府成立五年来的辉煌成就》，《人民日报》第3版，1952年6月9日。

⁶ “Шинэ монгол бичгийг хэрэгжүүлэх тухай ухуулах хөтөлбөр”, 1955 оны 10 дугаар сарын 14-ны өдөр. ӨМӨЗО-ны архивын газар. 310-1-68. 1-12.

толгой нь таньж цээжлэхэд амар, хэлбэр хялбар⁷ зэрэг монгол хэл дэх ярианы хэлийг үндсэндээ үнэн бодитойгоор тэмдэглэж, яриа болон бичгийн хөндийрэх үзэгдлээс зайлсхийсэнтэй салшгүй холбоотой мөртөө шинэ монгол үсэг цагаан толгойг цээжилчихвэл үсэг таньж уншиж, бичиж болно.⁸ Монгол дахь шинэ монгол үсэг суралцсан туршлагыг үндэслэвэл “Цагаан толгой”-г гуравхан өдөр суралцаад өдөр тутмын зохион бичлэг хийж болно. 1952 оны үеэс Монгол Улсын насанд хүрэгсдийн 92 хувь бичиг үсэгт тайлагдсан.⁹ ЗХУ-аас БНМАУ-д шинэ монгол үсгийн бичвэр, барлах, хэвлэл зэрэг тэргүүний мэргэжил, тоног төхөөрөмжөөр эхний ээлжид хангасан байна.¹⁰

БНХАУ байгуулагдсаны дараа БНХАУ-ын ХКН-ын Төв Хорооноос “Эв хамтын нийгэм» гадаад харилцааны төрийн бодлогыг авч ЗХУ болон бусад улстай дипломат харилцаа тогтоожээ. Эдгээр улстай үзэл санаа, соёлын талаар солилцох байр сууриа дээшлүүлэх, БНМАУ-тай соёлын талаар хамтрах хэлэлцээр тогтоосон байна.¹¹

1952 онд БНМАУ ба БНХАУ-ын хооронд “Монгол-Хятадын эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны гэрээ”-нд гарын үсэг зурснаар аж ахуй, соёлын талаарх харилцаанд багтай суурийг тавьсан юм. Удалгүй БНХАУ-аас Монголд “Зөрчлийн тухай”, “Пролетарийн диктатурын тухай”, “Ард түмний ардчилсан дарангуйлах засгийг өгүүлэх нь” зэрэг Мао Зе Дуны өгүүллүүдийг шинэ монгол үсэгт буулган хэвлэсэн нь БНХАУ, Монгол хоёр улсын соёлын харилцааны явц болон Мао Зе Дуны үзэл санааг Монголд таниулахад дөхөм болжээ.¹² 1955 оноос эхлэн монголын үйлдвэрлэл, барилга, бүтээн байгуулалтыг дэмжихээр БНХАУ-аас олон тооны ажилтныг Монголд илгээсний дотор монгол хэл болон шинэ монгол үсэг ойлгодог удирдах ажилтан ба орчуулагч нар ирсэн нь хятад ажилчин болон монгол хүмүүсийн хоорондоо харилцахад хялбар байв. Иймээс ӨМӨЗО-д шинэ монгол үсгийг түргэн дэлгэрүүлэх нь чухал байжээ.

Хоёр. ӨМӨЗО дахь шинэ монгол үсгийн өөрчлөлтийн явц

Монгол үсэг бичиг нь түүхэндээ олон удаагийн өөрчлөлтийг туулжээ. XIII зууны эхэнд Монголчууд эртний уйгур бичигт суурилсан монгол бичиг үсэг ашиглаж эхлэв. 1269 оны эхэнд Пагва лам Лодойжалцан Хубилай хааны зарлигийг хүлээж, төвд цагаан толгойн суурин дээр дөрвөлжин монгол үсэг буюу “пагва үсэг” зохиосон боловч Юаний төр мөхсөнөөр хэрэглэгдэхээ болив. 1307 онд монгол хэлний эрдэмтэн Чойжи-Одсэр эртний уйгур монгол үсгийг өөрчлөн шинэчилсэн нь монгол хэлэнд улмаар зохицсон байна. 1587 онд Аюуш гүүшийн “Али гали” үсэг зохиогдов. Мингийн сүүлч Манж Чин улсын эхэн үе буюу 1648

⁷ 《内蒙古自治区推行新蒙文》，人民日报》第3版，1955年9月4日。

⁸ 《关于目前蒙古文字问题》，1957年7月22日，中国外交部档案馆，106-00374-09，第59-71页。

⁹ “Ерөнхий сайд Жоу Энх Лай болон Цэдэнбалын ярилцсан тэмдэглэл”，1952 оны 10 дугаар сарын 15. Монгол Улсын Гадаад Харилцааны Яамны архив, Ф.5 Д.2 х.100, 156-175 дугаар нүүр.

¹⁰ “Шинэ монгол үсгийг хэрэгжүүлэх тухай ухуулах хөтөлбөр”，1955 оны 10 дугаар сарын 14. ӨМӨЗО-ны архивын газар, 310-1-68, 1-12.

¹¹ 图们, 朱东力, 《康生与“内人党”冤案》，北京, 中共中央党校出版社, 1995年, 第135页。

¹² 《中国文艺代表团和中国歌舞团访问蒙古人民共和国的情况》，中宣部编：《宣传通讯》第62期，第30-32页，1952年11月15日。

онд ойрадын эрдэмтэн Зая бандида хуучин монгол үсгийг сайжруулан өөрчлөн шинэчилснээр ойрадын ярианы хэлэнд улмаар зохицсон Тод бичиг үсэг зохиогдов. 1686 онд Өндөр Гэгээн Занабазар Соёмбо үсгийг Хэвтээ дөрвөлжин үсгийн хамт зохиов. Гэвч хуучин монгол үсэг нь улам будилаантай болсон учир сурахад нэлээд төвөгтэй байсан юм. Энэхүү бичгийг “тод монгол үсэг” гэдэг дээр нь ойрадаас бусад монгол үндэстний дунд өргөн хэрэглэгдээгүй юм. Хуучин монгол үсгийн онцлог (ярианы хэл болон бичгийн хэл нь нэгдэл үгүй, үсгийн хэлбэрийн хувирал нь олон, нэг үсэгт олон авиа байх, нэг авианд олон үсэг байх, зөв бичгийн дүрэм ба хэл зүй нь будилаантай, хөндлөнгөөр бичиж болохгүй зэрэг) нь монгол хэлийг уламжлан хэрэглэхэд болон сурган хүмүүжүүлэх ажилд зарим талаар хүндрэлтэй байжээ.

1941 оны эхэнд Монголд хуучин монгол үсэгт өөрчлөлт хийж латин галиг бүхий шинэ монгол үсгийг хэрэглэж эхэлсэн боловч 1946 оноос кирилл үсэг БНМАУ-ын албан ёсны бичиг болжээ.

Газар орны байдлаас шалтгаалж 1947 оноос өмнө Өвөр Монголын зүүн хязгаарын сургуулийн сурагчид шинэ монгол үсэгт суралцаж эхэлсэн. Үүний хамт “Ард түмний мэдлэг”, “Шинэ Өвөр монгол” зэрэг сэтгүүлд шинэ монгол үсгийн тухай өргөнөөр ухуулж танилцуулсан байна. Өөртөө засах орон байгуулагдсаны дараа ард олны соёлын түвшнийг дээшлүүлэх, аж ахуйг хөгжүүлэх, хөрш улсуудтай худалдаа арилжаа хийхийн тулд өөртөө засах орны тэргүүн Улаанхүү 1947 онд “Өвөр Монголын Цэрэг засгийн их сургууль» (Чичихар хот)-д монгол хэл бичгийг заан судлах тэнхимийг байгуулав.¹³ Тус тэнхим нь голдуу монгол хэл бичиг заах ба монгол хэл бичгийн өөрчлөлт хийх ажлыг эрхэлж байсан юм. Тус тэнхим байгуулагдсанаас хойш шинэ монгол үсэгт суралцаж, судалж эхэлжээ.

1949 оны 10 дугаар сард Төрийн явдлын яам Бээжинд БНХАУ-ын “Үсэг бичгийн өөрчлөлтийн нийгэмлэг”-ийг байгуулжээ. Үсэг бичгийн өөрчлөлтийн нийгэмлэг нь бүх улсын хэмжээнд зохион байгуулалттай, төлөвлөгөөтэйгөөр цөөн тоот үндэстний хэл, үсэг бичигт судалгаа хийв. 1951 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Төрийн явдлын яамны соёл, сурган хүмүүжлийн комиссоос «Цөөн тоот үндэстний хэл, үсэг бичгийг судалж удирдах комисс» байгуулжээ. Үүнээс гадна Мао Зе Дун, Жоу Энх Лай зэрэг намын удирдагч нараас улсын дотоод дахь цөөн тоот үндэстний үсэг бичгийн өөрчлөлт, онцгойлон Өвөр Монгол дахь үсэг бичгийн өөрчлөлтийг маш чухалд үзэж байв. Мао Зе Дун, Жоу Энх Лайгаас Монголын удирдагчтай ярилцахдаа Монгол дахь үсэг бичгийн өөрчлөлтийг хэрэгжүүлсэн тухай амжилт болон туршлагыг олонтоо сураглаж байжээ.¹⁴ БНХАУ, БНМАУ-ын аж ахуй, соёлын солилцоог идэвхжүүлэх шинэ монгол үсгийн өөрчлөлтийн туршлагыг судлахын тулд БНХАУ-ын Засгийн газраас монголд сурагч илгээн шинэ монгол үсгийг суралцуулав.

¹³ Жалсан, /贾拉森/. “Өгүүлэл болон дурсгалын зохиолын түүвэр”, Хөх хот: Өвөр Монголын Их Сургуулийн Хэвлэлийн Хороо, 1997, 5. Хичээлт, С. “Улаанхүүгийн үндэстний хэл бичгийн төрийн бодлогыг туушлуулах арга барил тогтолцооны тухай өгүүлэх нь”-аас дам ишлэв. Өвөр Монголын Үндэстний Их Сургуулийн сэтгүүл (Нийгмийн шинжлэх ухааны хэвлэл), 2011, 2, 15.

¹⁴ “Ерөнхий сайд Жоу Энх Лай болон Цэдэнбалын ярилцсан тэмдэглэл”, 1952 оны 10 сарын 15, Монгол Улсын Гадаад Харилцааны Яамны Архив, Ф.5 Д.2 х.100, 156-175.

1953 оны 5 дугаар сард ӨМӨЗО-ны Ардын комиссоос үсэг бичгийн өөрчлөлтийг хурдан хэрэгжүүлэхийн тулд монгол хэл бичгийн судалгааны нийгэмлэг (1955 онд «Монгол үсгийн өөрчлөлтийн комисс» хэмээн өөрчлөв)-ийг байгуулжээ. Монгол хэл бичгийн судалгааны нийгэмлэгийн харьяанд шинэ монгол үсгийн судалгааны комиссыг байгуулсан нь шинэ монгол үсгийн цагаан толгой, хэл зүй, зөв бичлэгийн дүрэм болон бичиглэх дүрэм зэргийг тусгайлан судалж эхлэв. 1954 онд “Монгол хэл бичиг” гэх сэтгүүлийг гаргасан нь хятадын ард түмэнд шинэ монгол үсгийг танилцуулан ухуулсан ба тус оронд шинэ монгол үсэгт суралцаж байгаа байдлыг харуулжээ. Үүнээс гадна ӨМӨЗО-ны Засгийн Ордноос (хоёр улс дипломат харилцаа тогтоосноос хойш Монголд байгаа Өвөр монгол ялтанг Хятадад буцаасан)-аас бусад хоригдолд шинэ монгол үсэг сургажээ.¹⁵

Ийнхүү 1957 оны 7 дугаар сард ӨМӨЗО-ны Ардын комиссоос шинэ монгол үсгийг хэрэгжүүлэх тогтоолыг тунхаглах үед ӨМӨЗО-д нэгэнт шинэ монгол үсгийг эзэмшсэн багш, найруулагч, орчуулагч олон болсон байна.

Үүнээс гадна ӨМӨЗО-д шинэ монгол үсгийг суралцаж хэрэглэхэд ЗХУ болон БНМАУ-ын олон талын дэмжлэгийг авч байв. Тавиад оны дундуур ЗХУ болон БНМАУ-аас тус тусдаа хэл шинжлэлийн мэргэжилтнийг БНХАУ-д илгээн, Өвөр монголын үсэг бичгийн өөрчлөлтөд тусламж үзүүлсэн.¹⁶ Монгол болон Өвөр монголын харилцааг сайжруулахын тулд БНХАУ, БНМАУ зөвлөлдөж 1956 онд Монгол Улсаас Хөх Хотод консул байгуулав.¹⁷ Мөн онд БНХАУ, БНМАУ, ЗХУ гурван улсыг холбосон төмөр зам нээгдсэн байна. Эдгээр арга хэмжээ нь БНХАУ, БНМАУ-ын соёлын солилцоог улмаар бататгахын зэрэгцээ Өвөр монголд шинэ монгол үсгийг суралцаж хэрэглэхэд ашигтай нөхцөлийг бүрдүүлсэн.

1955 оны 7 дугаар сарын 12-нд ӨМӨЗО-ны Ардын комиссын гурав дах удаагийн хурлаар шинэ монгол үсгийг хэрэгжүүлэх шийдвэр болон зургаан жилийн хугацаанд шинэ монгол үсгийг бүх талаар дэлгэрүүлэх төлөвлөгөөг батлав. 7 дугаар сарын 22-нд Ардын комиссоос шинэ монгол үсгийг хэрэгжүүлэх тухай зарлигийг өөртөө засах орны тэргүүн Улаанхүү баталсан байна.¹⁸ Гэвч Өвөр монголд шинэ монгол үсгийг хэрэгжүүлэхэд ахиц нь удаавтар байлаа. 12 дугаар сарын 6-нд Үндэстний хэл бичгийн шинжлэх ухааны хуралд үсэг бичгийн өөрчлөлтийн комиссын эрхлэгч Вү юй жан (吴玉掌)-аас цөөн тоот үндэстний үсэг бичгийг “түргэн бөгөөд шуурхай өөрчлөлтийг хийх” чиглэл өгөв.¹⁹ Үндэстний хэл бичгийн шинжлэх ухааны судалгааны хурлын зорилго болон шинэ монгол үсгийг хэрэгжүүлэх ажлын ахицыг түргэтгэхийн тулд 1956 оны 1 дүгээр сарын 16-нд ӨМӨЗО-ны Ардын комиссоос IX удаагийн хурлаар шинэ монгол үсгийг

¹⁵ 金永昌：《金永昌口述》，内蒙古苏尼特右旗政治协商委员会文史资料研究委员会编印，1988年，第54-55页。

¹⁶ “Дагуур хэл бичгийн ажлын хуралдаан дахь Зөвлөлтийн тусгай мэргэжилтэн Тодаев нөхрийн яриа”，1956 оны 12 дугаар сарын 20-27 өдөр，ӨМӨЗО-ны архивын газар，243-1-339，93-96. “Өвөр Монголын Үндэстний Их Сургуулийн сэтгүүл” (нийгмийн шинжлэх ухааны хэвлэл)，2011，2，7.

¹⁷ 《同蒙古人民革命党代表团的谈话和印发谈话记录的批语》，1956年9月24日，《建国以来毛泽东文稿（1956年1月—1957年12月）》（第六册），北京：中央文献出版社，1997年，第213—223页。

¹⁸ “Өвөр Монголын Өөртөө Засах Орны Ардын комиссоос шинэ монгол үсгийг хэрэгжүүлэх тухай шийдвэрийг зарласны учир”，1957 оны 7 дугаар сарын 22-ны өдөр，ӨМӨЗО-ны архивын газар，310-1-66，27-29.

¹⁹ 《民族语文科学讨论会在京开幕》，人民日报》第1版，1955年12月7日。

хэрэгжүүлэх төлөвлөгөөг зургаан жилээс дөрвөн жил болгов.²⁰ Энэхүү төлөвлөгөөг биелүүлэхийн тулд ӨМӨЗО-ын Ардын комиссоос боловсролын анги нээх, шагнаж хөхиүлэх, монгол хэлний тусгай мэргэжилтэн урих зэрэг ажлыг зохион байгуулжээ.

1955 оны 10 дугаар сард ӨМӨЗО-ны боловсролын тэнхимээс Хөх хотод шинэ монгол үсгийн ангийг нээхдээ эл аймаг, хотын удирдах ажилтнууд оролцох хэрэгтэйг шаардав. Уг ангид ӨМӨЗО-ны багшийн эгнээнээс гадна бас Шинжань, Хөхнуур, Хармөрөн, Гирин зэрэг муж болон үндэстний бүх удирдах ажилтнууд “монгол, хятад хоёр хэлийг сурч чадсан байх хэрэгтэй”-г онцолжээ.²¹

Өвөр монголд үсэг бичгийн өөрчлөлт өрнүүлсний дараа өөртөө засах орны дэд тэргүүн Хайфунга өөрийн албан хаагчдадаа мягмар гарагт 2 цагийн чөлөөгөөр шинэ монгол бичиг суралцах хэрэгтэй гэж чухалчилсан бөгөөд²² өөртөө засах орны шууд харьяа албан хаагч нарын шинэ монгол үсгийн сургалтын чанар болон ахицыг дээшлүүлэхийн тулд 9 дүгээр сарын 7-нд ӨМӨЗО-ны Хөх хот дахь тэргүүн албан хаагч нарт шинэ монгол үсэг сургах комиссыг байгуулав.²³ Гэвч албан хаагч нарын суралцах цаг нь хязгаартай, үргэлжийн хөдөө болон албан ажлаар гадагшаа явах зэрэг нь нөлөөлж сурлагын амжилт тааруухан байв.²⁴ Хэдийгээр ийм боловч Хөх хотын 1300 албан хаагч нар шинэ үсэг сурсан ба үүнээс 100 гаруй нь хятад үндэстэн байжээ.²⁵ 1956 оны 10 дугаар сар гэхэд Хятад даяар 5178 тооны багш, албан хаагчид шинэ монгол үсэг сурч чамлахааргүй амжилттай байв.

ӨМӨЗО-ны Ардын комиссоос боловсролын үйл ажиллагаанаас гадна шинэ монгол үсэгт сайн суралцсаныг шагнаж хөхиүлэх дүрэм тогтоож, амжилт гаргагсдыг шагнажээ. 1956 оны 10 дугаар сарын 19-нд ӨМӨЗО-ны намын хорооны дарга Ван зай тиан (王再天)-аас өөртөө засах оронд монгол хэлийг сайн суралцсаныг шагнаж тухай тушаал”-д гарын үсэг зурсан байна. Үүнд: “Шилдэг бүтээмжтэй монгол үсгийн тусгай мэргэжлийн ажилтан болон ажлын чөлөөний шинэ монгол үсгийн багш нарт 30-100 юань хүртэл, монгол сургууль, боловсролын ангийн сурагч болон шинэ монгол үсэг өөрөө сурагсдыг 20-60 юань хүртэл шагнана гэжээ. Шагналын мөнгө нь тухайн үеийн энгийн ажилтны нэг сар буюу хэдэн сарын цалинтай дүйж байв. Орчуулагч, найруулагч, сурвалжлагч, эрдэм шинжилгээний ажилтан, дээд, дунд сургуулийн багш, улсын байгууллага, нам ба олон нийтийн, аж ахуйн байгууллагад монгол, хятад хоёр хэлээр харилцан ажиллаж байгаа албан хаагч ажилтанд шагнал олгоно” гэжээ.²⁶

²⁰ “Монгол хэл бичгийн судалгааны хөтөлбөр”, 1956 оны 6 дугаар сарын 5. ӨМӨЗО-ны архивын газар, 243-1-261, 95-97.

²¹ “Шинэ монгол бичгийг хэрэгжүүлсэн шинэ үе шаг” Өвөр Монголын хэл бичгийн ажлын комисс, 1956 оны 11 дүгээр сар, ӨМӨЗО-ны архивын газар, 310-1-67. 1-3.

²² “Сурган хүмүүжлийн тэнхимийн үндэстний кадр нараас үндэстний хэл бичгийг суралцаж ашигласан байдал”, 1956 оны 5 дугаар сарын 12, ӨМӨЗО-ны архивын газар, 243-1-261. 101-104.

²³ “Өвөр Монголын Өөртөө Засах Орон болон Хөх хот дахь шинэ монгол үсэг суралцах нэгдүгээр дэсийн комиссыг байгуулах тухай мэдэгдэл”, 1956 оны 9 дүгээр сарын 4, ӨМӨЗО-ны архивын газар, 243-1-261, 139-142.

²⁴ “Эл шууд харьяа байгууллагаас албан бичиг болон хуралдаандаа үндэстний хэл бичгийг хэрэглэснийг байцаасан тухай мэдүүлэлт”, 1956 оны 6 дугаар сарын 16, ӨМӨЗО-ны архивын газар, 243-1-261, 62-69.

²⁵ 《内蒙古自治区十万人参加新蒙文学习》，《人民日报》第7版，1956年11月25日。

²⁶ 10 сарын 17-нд Ван зай тианаас шагналын мөнгийг нь хорин төгрөгөөс доош гэдгийг гучаас зуун төгрөг гэж, арван төгрөгөөс доош гэдгийг хориос жаран төгрөг гэж өөрчлөв. “Өвөр Монголын Өөртөө Засах Орон дахь монгол хэлийг хэрэглэж суралцсаныг шагнахыг хэрэгжүүлэх аргын

1957 оны 3 дугаар сарын 23-нд ӨМӨЗО-ны Ардын комиссын 22 дугаар хуралдаанаар “монгол хэл бичгийн ажлыг шагнах тухай туршин хэрэгжүүлэх арга”-ыг баталжээ.²⁷ Тус арга нь шинэ монгол үсгийг ашиглаж чадах чадварыг үндэслэж дөрвөн дэс хуваасан бөгөөд тус комиссын «Монгол үсэг бичгийн өөрчлөлтийн комисс» (шинэ монгол үсгийг хэрэгжүүлэх комисс) нарийн бичгийн газар, сурган хүмүүжлийн засаг захиргааны яамнаас үнэлж шагнажээ.²⁸

1950 онд Өвөр монголын Багшийн тусгай мэргэжлийн сургууль (одоогийн Өвөр Монголын Багшийн Их Сургууль) болон Өвөр Монголын Их Сургууль (1957 онд байгуулагдсан) нь БНМАУ-аас хэл шинжлэлийн арваад мэргэжилтэн урьж шинэ монгол үсгийг нэг төрлийн гадаад хэлний сургалт болгон өдөр бүр хоёр цагаар шинэ монгол үсэг зааж эхлэв.²⁹ Мэргэжилтнүүдийг буцахад Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Жоу Энх Лайгаас тэд нарын Өвөр монгол дахь ажил, үсэг бичгийн өөрчлөлтөд үзүүлсэн чухал нэмрийг сайшаасан бөгөөд нөхөрлөлийн дурсгалт медаль бэлэглэжээ.³⁰

ӨМӨЗО-ны Ардын комиссоос дээрх мэт арга хэмжээг авснаар Өвөр монгол дахь үсэг бичгийн өөрчлөлт зохих хэмжээний амжилт олсон байна. 1956 оны 5 дугаар сарын 22-нд БНХАУ-ын Шинжлэх ухааны хүрээлэнгийн цөөн тоот үндэстний хэл шинжлэлийн судлалын газар болон ӨМӨЗО-ны “Монгол үсэг бичгийн өөрчлөлтийн комисс”-той хамтран Монгол үндэстний хэл шинжлэлийн хурлыг Хөх хотод хийжээ. Тус хуралдаанаас шинэ монгол үсгийг сурч хэрэглэх төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн зөвийг дахин нотолсноор 1956 оны 9 дүгээр сараас эхлэн Өвөр монгол даяар дээд, дунд, анх дунд, бага сургуулиуд шинэ монгол үсгийн хичээлийг жинхэнээр хэрэглэж эхэлсэн байна.³¹ Олон тооны сургуулийн багш нар үндсэндээ шинэ монгол үсгээр сурч хичээллэж сурагчид нь шинэ монгол үсгээр найруулсан бүх төрлийн хичээлийн номыг үзэж эхэлсэн байна.³² Бүрэн бус бүртгэлийг үндэслэвэл, 1956 онд Өвөр монгол даяар шинэ монгол үсгээр хичээллэх сурагч 90 мянга гаруй, монгол албан хаагч нар 1300 гаруй байжээ. Үүнээс гадна монгол үндэстний тариачид, малчид, цэрэг, офицер, ажилтан албан хаагч гэх мэт 160 мянга гаруй хүмүүс шинэ монгол үсгийг суралцах хөдөлгөөнд нэгдсэн байна.³³

тухай мэдэгдэл” 1956 оны 9 дүгээр сарын 19, ӨМӨЗО-ны архивын газар 243-1-261, 143-145.

²⁷ “Монгол хэл бичгийн ажлыг шагнах тухай туршин хэрэгжүүлэх аргыг зарласны учир”, 1957 оны 4 дүгээр сарын 20, ӨМӨЗО-ны архивын газар, 243-1-339, 6-8.

²⁸ Шагналын мөнгийг дөрвөн дэс хуваана. Нэгдүгээр дэс нь 90 төгрөг, хоёрдугаар дэс нь 70 төгрөг, гуравдугаар дэс нь 50 төгрөг, дөрөвдүгээр дэс нь 30 төгрөг. Шагнал тогтоох нөхцөл нь: нэгдүгээр дэс: монгол хэлээр дадамгай зохион бичих болон монгол хэл судлах, хятад хэлээс монгол хэлэнд түргэн буулгаж чадах. Хоёрдугаар дэс: Монгол хэлээр дадамгай зохион бичих болон монгол хэл судлах, хятад хэлээс монгол хэлэнд нийлэмжтэй буулгаж чадах. Гуравдугаар дэс: Монгол хэлээр дөхөмхөн зохион бичих болон энгийн албан бичиг харж шийдвэрлэж чадах. Хятад хэлээс Монгол хэлэнд овоо нийлэмжтэй буулгаж чадах. Дөрөвдүгээр дэс: монгол хятад хоёр хэлээр овоо нийлэмжтэй ажиллаж чадах.

²⁹ Бай лин. «Оюун нөхрийг сурвалжилсан тэмдэглэл», Хөх хот, 2017 оны 5 сарын 20.

³⁰ Дашдаваа, Ч. Болд, Ч. «Жоу Энх лай ба Монгол орон» Улаанбаатар. 2015, 91.

³¹ 进一步贯彻执行发展少数民族语文的政策蒙古语族语言讨论会在呼和浩特举行》，1956年5月24日，《人民日报》第3版；《蒙古语族语言科学讨论会闭幕》，1956年5月31日，《人民日报》第1版。

³² 《内蒙古十万蒙民今年将学会新蒙文》，1956年7月5日，《人民日报》第4版。

³³ “Шинэ монгол бичгийг хэрэгжүүлэх шинэ үе шат” Өвөр Монголын хэл бичгийн ажиллагааны комисс, 1956 оны 11 дүгээр сар. ӨМӨЗО-ны архивын газар, 310-1-67, 1-3.

Гурав. ӨМӨЗО дахь шинэ монгол үсгийн өөрчлөлтийн явцад бий болсон асуудал

1955-1958 он хүртэлх хугацаанд өвөр монгол дахь үсэг бичгийн өөрчлөлт нь хэдийгээр бүтэмжтэй боловч бэрхшээл олон тулгарав..

Юуны өмнө, ӨМӨЗО-ны зарим албан хаагч нар бичиг үсгийн өөрчлөлтийг чухалд үзэлгүй харин бүр басамжилсан байна. “Аж ахуйн бүтээн байгуулалтын өрнөлтийн аясаар соёлын бүтээн байгуулалтын өрнөлт байх нь лав” гэж Мао Зе Дуны ярьсныг³⁴ нийгэм журмын хувьсгал нь зөвхөн аж ахуйн бүтээн байгуулалтыг чухалчилна гэж нэгэн бүлэг хүмүүс эндүү ойлгосноос соёлын бүтээн байгуулалтыг үл ойшоох буюу удаашруулсан. Иймэрхүү үзэл бодол нь ӨМӨЗО-ны албан хаагч нарын дунд шинэ монгол үсгийн өөрчлөлтөд идэвхтэй бус хандаж, та нар “шинэ монгол үсгийг хэрэгжүүлэх хандлага нэгэнт өнгөрчихсөн, гүнзгий сурах шаардлагагүй, үргэлжийн хөдөө ажилтай буюу албан ажлаар байнга явдаг учраас суралцах цаг байхгүй” гэж үзэж байжээ.³⁵ Мөн зарим албан хаагч “шинэ монгол хэл ашиглах нь цөөн мөртөө дандаа яршиг удна”, “хятад хэл л чухал, монгол хэл чухал биш”, “дэмий л маяглаж байгаа явдал”, “монгол хэл сураад ашиглахгүй, орчуулга хийх ч биш, надад хэрэггүй” зэргээр үзэж зарим байгууллага шинэ монгол үсэгт суралцсангүй.³⁶ Жишээлбэл: Өөртөө засах орны эрүүл мэндийн тэнхимийн хориод албан хаагч суралцсангүй, байгалийн тэнхимийн нийт 11 албан хаагчаас гуравхан хүн суралцсан, мал аж ахуйн тэнхимийн нийт 20-иод албан хаагчаас 5 хүн суралцсан зэрэг болно.³⁷ Тэр ч байтугай, хуучин монгол үсгийг хэдэн зуун жил хэрэглэчихсэн, монголын түүх, соёл хуучин монгол үсгээр тэмдэглэж хадгалсан, үүнтэй үсэг ондоо шинэ монгол үсгийг хэрэглэх нь бодит байдалтай нийцэхгүй гэх зэргээр Өвөр монгол дахь зарим албан хаагч нар эсрэг саналтай байв. Эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд 1956 оны 11 дүгээр сарын 26-нд ӨМӨЗО-ны Ардын комисс хуралдаж Өвөр монгол дахь үсэг бичгийн өөрчлөлт дэх “дээд шатны шийдвэрийг доод шат нь үл тоох, дундах нь чухалд үзэхгүй” байдлыг онцлон шүүмжилжээ.³⁸

1957 оны 7 дугаар сарын 3-нд БНХАУ, ЗХУ, БНМАУ гурван улсын хамтарсан шинэ монгол үсгийн эрдэм шинжилгээний хурал Улаанбаатарт болж шинэ монгол үсгийг хэрэгжүүлэх явц дахь асуудлуудыг хэлэлцжээ. Тус хуралдаанд Ц.Дамдинсүрэн болон Б.Ринчений зөрүү саналуудыг шийдвэрлэх ёстойг дурджээ. Гурван улсын төлөөлөгчдөөс Ц.Дамдинсүрэнгийн “Зөв бичгийн дүрэм ба бичих дүрэмд засвар оруулах”, Б.Ринчений “Шинэ монгол үсгийн цагаан толгойд засвар оруулах” саналаас сонгож холин авахдаа эрдэмтдийн санаа бодлыг нэгтгэх чухал байсан авч олон тооны төлөөлөгчдөөс доктор Б.Ринчений саналыг дэмжсэн байна.

³⁴ 《在中国人民政治协商会议第二届全国委员会第二次全体会议上的发言吴研因的发言》，1956年2月13日，《人民日报》第5版。

³⁵ “Сурган хүмүүжлийн тэнхимийн үндэстний кадр нарын үндэстний хэлээ хэрэглэсэн ба суралцсан байдал”, 1956 оны 5 дугаарын 12, . ӨМӨЗО-ны архивын газар, 243-1-261, 101-104.

³⁶ “Есөн жилийн турш өвөр монголын өөртөө засах орон дах хэл бичгийн ажлын байдал жич шинэ монгол бичгийг бүх талаар хэрэгжүүлэх тухай санал (төсөл)”, 1956 оны 4 дүгээр сарын 29, ӨМӨЗО-ны архивын газар, 310-1-67, 9-24.

³⁷ “Эл шууд харьяа байгууллагын албан бичиг болон хуралдаандаа үндэстний хэлээ хэрэглэснийг байцаасан мэдүүлэлт”, 1956 оны 6 дугаар сарын 16, ӨМӨЗО-ны архивын газар, 243-1-261, 62-69.

³⁸ “Үндэстний хэлээ омтгойлсон байдлыг залруулах тухай зарлал”, 1956 оны 11 дүгээр сарын 26, ӨМӨЗО-ны архивын газар, 243-1-261, 155-159.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга Ю.Цэдэнбал ч өөр хоорондоо Б.Ринчений саналыг дэмжиж байсан нь харагддаг. ЗХУ-ын төлөөлөгчид Б.Ринчений саналыг эрс эсэргүүцэж байсан юм. Хэрвээ монголоос Б.Ринчений саналыг хүлээн авбал Зөвлөлтийн кирилл үсэгтэй зөрүүтэйгээр үл барам ЗХУ-ын нутагт байгаа Буриад Монгол, Халимаг Монгол нь ч кирилл үсэгт өөрчлөлт явуулах болно. Тус хуралдаан арван өдөр явагдсан боловч гурван улсын төлөөлөгчид санал нэгтэй шийдвэрийг гаргаж чадсангүй.

Тухайн үед Монголд монгол хэл, үсэг бичигт нийцсэн зөв бичгийн дүрэм болон хэл зүй бүрэн боловсроогүй байсан учраас Өвөр монголд шинэ монгол үсэг хэрэгжүүлэх явц удааширсан. Хуучин монгол үсэгт байх олонх авиа нь орос хэлэнд байхгүй, орос хэлний зарим авиа нь ч монгол хэлэнд байхгүй гэх мэт олон асуудал тулгарсан. Жишээлбэл, монгол хэлний хамжин шүргэх гийгүүлэгч (ДЖ), (ДЗ) нь орос хэлэнд байхгүй, зөвхөн гийгүүлэгч (Ж) болон түрэх авиа (З) бий. Монгол хэлэнд дөхмийн тулд (ДЖ) болон (ДЗ)-г хэрэглэсэнгүй, харин орос хэлний (Ж) болон (З)-г шууд хэрэглэсэн нь шинэ монгол үсгийн бичлэгийн явцад олон зүйлийн үсэг илэрснээс үсэг бичиг нь нэн замбараагүй мэт харагдах болжээ. Жишээлбэл: (Го можо “Го мо ру”), Жуков (Зоо ке фу). Тэгвэл орос хэлний (Н)-д хэлний үзүүрийн авиа, хэлний угийн авиа байхгүй харин монгол хэлэнд байдаг. Орос хэл нь (Н)-ийг зөөлөн авианы тэмдгээр тэмдэглэдэг, хэлний угийн (Н)-д зөөлөн авианы тэмдэг байхгүй, хэлний үзүүрийн (Н)-г зөөлөн авианы тэмдгээр тэмдэглэдэг. Жишээлбэл: (шанхай)-г (шан хай) гэж бичдэг, харин (Жоу эн лай)-г (Чжоу-Эньлай) гэж бичдэг. Үүнээс гадна монгол (Ө), (Ү) хоёр үсэг цагаан толгойд бий. Орос хэлэнд харин байхгүй. Иймээс Өвөр монголд шинэ монгол үсэг хэрэгжүүлэх ажлыг сайжруулах шаардлагатай байжээ.

Сүүлдээ ЗХУ, БНМАУ, БНХАУ нь шинэ монгол үсгийг хэрэгжүүлэх явц дахь асуудлыг ярилцаж шийдвэрлэхэд хүндрэлтэй болов. 1956 онд монгол хэл шинжлэлийн эрдэмтэд шинэ монгол үсгийн цагаан толгойн тухай асуудлуудыг шийдвэрлэхээр оролдсоныг Монголын “Үнэн сонин”-д нийтэлжээ.³⁹ Монголын эрдэмтдээс зөв бичлэгийн дүрэм болон цагаан толгойд засвар оруулах талаар өөр өөр саналтай байснаас Ц.Дамдинсүрэнгээр⁴⁰ төлөөлүүлсэн зөв бичгийн дүрэмд засвар оруулах санал, нөгөө нь Б.Ринченээр⁴¹ төлөөлүүлсэн шинэ монгол үсгийн

³⁹ “Товч мэдээ”, Үнэн 1957/2/24.

⁴⁰ Ц.Дамдинсүрэн (1908-1986) утга зохиолч, эрдэмтэн, орчуулагч. 1908 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол улсын Дорнод аймгийн Матад суманд малчин айлд төрсөн. 1925 онд Тамсаг булаг дахь цэргийн хорооны бичээч, 1926 онд Монголын Хувьсгалт Залуучуудын эвлэлийн төв хорооны байнгын тэргүүлэгч, 1927-1929, 1942-1945 онд “Үнэн” сонины эрхлэгч, 1929-1930 онд Үйлдвэрчний төв зөвлөлийн дарга, Говь-Алтай аймагт хамтралын сургагч, 1932-1933, 1938, 1945-1946 онд Шинжлэх ухааны хүрээлэнгийн судлаач, 1950-1953 онд Шинжлэх ухааны хүрээлэнгийн дарга, 1953-1955 онд Монголын зохиолчдын хорооны дарга, 1955 оноос Монгол Улсын Их Сургуулийн багш, 1959-1963 онд ШУА-ийн [1959-1961 он хүртэл Шинжлэх Ухаан, Дээд боловсролын хүрээлэн] Хэл зохиолын хүрээлэнгийн захирал, 1963 оноос насан эцэслэх хүртлээ ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнд эрдэм шинжилгээний ахлах ажилтнаар ажиллаж байв.

⁴¹ Б.Ринчен 1905 оны 11 дүгээр сард Сэлэнгэ аймгийн Алтанбулаг суманд төрсөн. Хэл зохиолын хүрээлэнгийн дуун ухааны тасгийн доктор, профессор, академич. 1924 онд Зөвлөлтийн Ленинградын Дорно дахины хэл шинжлэлийн судалгааны газар болон 1956 онд Унгар Улсад хэл шинжлэлийн докторын зэрэг хамгаалсан. 1927 оноос Сурган хүмүүжлийн яамны соёлын судалгааны газар, 1942 оноос “Үнэн сонин”-ний найруулах хэлтэст 16 жил ажиллажээ. 1961 онд Шинжлэх Ухааны Академийн жинхэнэ гишүүн, академичаар сонгогдсон.

цагаан толгойд дахин засвар оруулах бөгөөд цагаан толгойд үсэг нэмэгдүүлэх гэсэн санал, тэр ч байтугай цөөн тооны эрдэмтэд хуучин монгол үсгээ дахин хэрэглэхээр санаачилсан ба 1957 оны 1 дүгээр сард МАХН-ын Төв Хорооны V бүгд хуралдаанд Намын Төв Хорооны хоёрдугаар нарийн бичгийн дарга Ч.Сүрэнжаваас Ц.Дамдинсүрэнгээр төлөөлүүлсэн зөв бичгийн дүрэм болон бичих дүрэмд засвар оруулах саналыг дэмжихээ илэрхийлжээ. Удалгүй Монголын “Үнэн сонин”-д Б.Ренчинээр төлөөлүүлсэн шинэ монгол үсгийн цагаан толгойд засвар оруулах саналыг олонх хүмүүс дэмжихгүй гэж нийтэлжээ.⁴² Гэвч Монголын одоо хэрэглэж байгаа шинэ монгол үсгийн цагаан толгой болон зөв бичгийн дүрмээс харвал, МАХН-ын Төв Хороо болон Засгийн газар хоёр талын саналыг хүлээж авч Ц.Дамдинсүрэнгийн зөв бичгийн дүрэм, Б.Ринчений шинэ монгол үсгийн цагаан толгойд засвар оруулах гэсэн саналыг системчилж зөв бичгийн дүрэм болон бичих дүрмийг тогтоож цагаан толгойд засвар оруулсны хамт “Ө”, “Ү” хоёр үсгийг нэмсэн байна.

Дөрөв. ӨМӨЗО дахь шинэ монгол үсгийн өөрчлөлт зогсонги байдалд орсон нь

1958 оны 3 дугаар сард Өвөр монголд шинэ монгол үсгийг сурч хэрэглэхээ болихоор зарлажээ. Үүнд дараах хоёр зүйлийн шалтгаан бий. Нэгд Хятад, Зөвлөлт хоёр улсын харилцаа муудсан ба латин галигт суурилсан “Хятад хэлний галиг үсэг”-ийн үсэг бичгийн өөрчлөлт хийхээр шийдвэрлэсэн. Хоёрт Шинэ монгол үсэг нь зөв бичгийн дүрмээ өөрчлөх болон цагаан толгойд засвар оруулах зэрэг олон талын асуудал байв.

1956 онд ЗХУ, Польш, Унгарт цэргээ оруулсны дараа БНХАУ-аас Зүүн Европын явдалд эхлэн оролцсон нь БНХАУ-ын ХКН-ын социалист систем дэх байр суурь ихээхэн өргөжив.⁴³ Онцгойлон 1957 оны 11 дүгээр сарын Москва хотноо болсон хуралдаанд БНХАУ үзэл суртлын нэг байр суурьтай улсуудын дундаа нэр хүнд, байр суурь, улс төр болон онолын хувьд ЗХУ-тай адил хэмжээнд хүрчээ.⁴⁴ Энэ үед Мао Зе Дунаас БНХАУ-ын гадаадтай харилцах төрийн бодлогыг дахин тодорхойлсон ба ЗХУ-д хандах байдал аажмаар хувирахын хамт улсын дотоод дахь төрийн бодлогоо ч улам нарийсгасан байна. Жишээлбэл, үсэг бичгийн өөрчлөлтийн хувьд Мао Зе Дунаас “үсэг бичгийг заавал өөрчилнө, дэлхийн латин галигийг хэрэглэх хамтын хандлагатай нийлэх хэрэгтэй” гэж зааварлав. Энэ нь Мао Зе Дунаас эл үндэстний үсэг бичгийн өөрчлөлтийг зогсоох хандлага илэрч, латин үсэг хэрэглэх саналыг дэмжжээ.⁴⁵

ӨМӨЗО-д шинэ монгол үсгийн өөрчлөлтийн дараа шинэ монгол үсгийг хэрэглэсэн нь маш бага, зөвхөн Өвөр монгол болон Монголд л хэрэгжүүлсэн юм. Энэ нь ӨМӨЗО-ны цөөн тоот үндэстэн болон хятад үндэстний харилцаа, улсын дотоод дахь хэрэгцээ болон олон улсын нийгмийн хөгжлийн хандлагатай нийцэхгүй нь тодорхой болжээ. БНХАУ-аас дэлхийн бусад улстай харилцахад юуны өмнө хялбар, ойлгомжтой, бичлэг дөхөм бичгээр улсын дотоод дахь үндэстний үсэг бичгийг

⁴² “Олон тооны уншигч цагаан толгойд засвар оруулахыг дэмжихгүй”, Үнэн, 1957/4/8.

⁴³ 沈志华：《无奈的选择—冷战与中苏同盟的命运（1945-1959）》，北京：社会科学文献出版社，2013年，第495页。

⁴⁴ 沈志华：《无奈的选择—冷战与中苏同盟的命运（1945-1959）》，北京：社会科学文献出版社，2013年，第95页。

⁴⁵ 吴玉章：《文字改革文集》，北京：中国人民大学出版社，1978年，第101页。

өөрчлөх шаардлагатай тулжээ. Иймийн тул 1957 оны 11 дүгээр сарын 1-нд Төрийн зөвлөлийн хорооны 60 дахь удаагийн хуралдаанаар латин галигт суурилсан “Хятад хэлний галиг үсгийн дүрмийн төсөл”-ийг хэрэгжүүлэхээ зарлав.⁴⁶ БНХАУ-ын ХКН-ын Төв Хорооноос хятад хэлний галиг үсгийн дүрмийг баталснаар үсэг бичгийн өөрчлөлтийн бэлтгэлийг хийж эхлэв.

1949 оны 10 дугаар сард БНХАУ-ын Төрийн зөвлөлийн хорооноос “Үсэг бичгийн өөрчлөлтийн нийгэмлэг”-ийг байгуулсны дараа хятад үсгийг хялбарчлах болон хятад хэлний галиг үсгийн төслийг туурвиж эхэлсэн. 1952 оны 2 дугаар сард БНХАУ-ын “Үсэг бичгийн өөрчлөлтийн судалгааны комисс” (дараагаар үсэг бичгийн өөрчлөлтийн комисс) байгуулагдсаны дараа хятад үсгийг хялбарчлах болон хятад хэлний латин үсгийн дүрмийг эмхэтгэв. 1954 оны 12 дугаар сард “Үсэг бичгийн өөрчлөлтийн комисс”-д хятад хэлний галиг үсгийн дүрмийн комиссыг байгуулсан нь хятад хэлний латин үсгийн төсөлд системтэй судалгааг хийжээ. 1955 оны 10 дугаар сард “Үсэг бичгийн өөрчлөлтийн комисс”-оос хятад хэлний галиг үсгийн төслийг зургаан (Хятад үсгийн зурлагын төлөв дөрөв, латин галигийн нэг, орос галигийн нэг) зүйлээр тогтов.⁴⁷ Үүнээс үзэхэд хятад хэлний галиг үсгийн өөрчлөлтийн бэлтгэл ажил үндсэндээ дууссаныг харуулж байна.

Хятад хэлний галиг үсгийг хэрэгжүүлэхийн тулд 1958 онд БНХАУ-ын улс төрийн зөвлөгөөний хуралдаан дээр Жоу Энх Лайгаас “Үсэг бичгийн өөрчлөлт дэх одоогийн үүрэг” гэх илтгэл тавьжээ. Тус илтгэлд “Хятад хэлний галиг үсгийн төсөл”-ийг дээд хэмжээгээр үнэлэхийн хамт хятад хэлний галиг үсгийн энэ төсөл нь үндэстний үсэг бичгийн хөгжил болон өөрчлөлтөд ашигтай, хожмын үндэстэн хоорондох суралцах ба харилцаанд чухал ач холбогдолтой юм гэж тодорхойлжээ.⁴⁸ 1958 оны 2 дугаар сарын 1-нд Бээжинд болсон БНХАУ-ын нэгдүгээр хугацааны Бүх ардын төлөөлөгчдийн их хурлын V хуралдаан дээр “Хятад хэлний галиг үсгийн төсөл”-г баталсан байна. Удалгүй үндэстний хэл бичгийн ажлын хүрээнд “Үг хэлийг сурталчлах” суртал ухуулга болж, Хятад даяар хятад хэлний галиг үсэгт суралцах хөдөлгөөн өрнөв. Мөн оны 3 дугаар сарын 28-нд БНХАУ-ын Шинжлэх ухааны хүрээлэн болон “Үндэстний хэрэг эрхлэх комисс”-ын II дугаар удаагийн цөөн тоот үндэстний хэл шинжлэлийн хуралд бүх хүчээ дайчилж, цөөн тоот үндэстний хэл бичгийн ажлын их үсрэнгүй хөгжлийн үүргийг биелүүлнэ гэжээ.⁴⁹ Гэвч БНХАУ-д хятад хэлний галиг үсэгт суралцах тухай дотоодод хэсэг хүмүүс эсрэг саналтай байснаас үл барам⁵⁰ гадаадын зарим орны сонин сэтгүүлд цуу тарааж гүтгэж байжээ.⁵¹

Үүнээс гадна 1947-1958 онуудад ӨМӨЗО дахь шинэ монгол үсгийн өөрчлөлт, түүний давуу тал болон өөрчлөлт, хир бүтээмжийг ухуулахыг онцолсноос биш

⁴⁶ 吴玉章：《关于当前文字改革工作和汉语拼音方案的报告》，《文字改革》，1982年第2期；《关于当前文字改革工作和汉语拼音方案的报告一九五八年二月三日在第一届全国人民代表大会第五次会议上》，1958年2月14日，《人民日报》第2版。

⁴⁷ 《中央关于文字改革工作问题的指示》，1956年1月，中宣部编：《宣传通讯》第181期，第4-15页。

⁴⁸ “Шинэ монгол үсгийг хэрэгжүүлэхээ больж хуучин монгол үсгийг үргэлжлэн сурч хэрэглэх тухай ухуулах хөтөлбөр”，1958 оны 5 дугаар сарын 30, ӨМӨЗО-ны архивын газар, 310-1-68, 22-27.

⁴⁹ 《少数民族语文工作需要促进》，1958年4月19日，《人民日报》第1版。

⁵⁰ 《对文字改革的不同意见》，1957年5月9日，中共中央宣传部编印《宣教动态》，总第227期，河北省档案馆，864-2-424，第14-16页。

⁵¹ 《瑞士报刊对我文字改革的反映》，1958年4月7日，中共中央宣传部编印《宣教动态》，总第376期，河北省档案馆，864-2-442，第15-16页。

багш, сурагчаас суралцахад тулгарсан бодитой асуудлыг үл хайхарсан байна. БНХАУ-ын ХКН-ын удирдагчид болон БНМАУ-ын удирдагч нартай санал солилцохдоо зөвхөн монгол дахь үсэг бичгийн өөрчлөлтийн дараах амжилт бүтээмжийг л ярилцсанаас биш харин өөрчлөлтөд оршиж байгаа асуудлыг дурдаагүй юм. Үүний хамт шинэ монгол үсгийг нэвтрүүлэхэд “Зөв бичгийн дүрэм” болон “Цагаан толгойд засвар оруулах” дээр зөрүү саналтай байсан учир хэрэглэж байгаа хугацаанд бичлэгийн хувьд замбараагүй байдалтай. Монгол улсын үсэг бичгийн өөрчлөлтийн хэлбэрийг шуудхан ишилснээс ӨМӨЗО-ны үсэг бичгийн өөрчлөлтөд тохироход ихэд хүндрэлтэй байжээ.

1955 онд хэл шинжлэлийн эрдэмтэн Б.Ринчен Улаанбаатар хотоос Өвөр монголд хүрч Өвөр монголын багшийн дээд сургууль болон шинээр байгуулагдсан Өвөр Монголын Их Сургуулийн багш, сурагчдад монгол хэлний хичээл заахдаа ӨМӨЗО-д шинэ монгол үсгийн өөрчлөлтийг хэрэгжүүлэхээ больж, уламжлалт монгол соёлоо чухалчлан, хуучин монгол үсгээ хэрэглэхийг уриалжээ. Б.Ринченээс БНХАУ-ын удирдлагуудад захидал илгээхдээ Монгол дахь шинэ монгол үсгийн өөрчлөлтийн явцад байгаа асуудлуудыг ярьж, Өвөр монгол дахь шинэ монгол бичгийн өөрчлөлтийн хөдөлгөөнийг зогсоох санаачилга гаргажээ.⁵² Б.Ринчений яриа илтгэл болон захидал нь Өвөр монгол дахь шинэ монгол үсгийн өөрчлөлтийн явц дахь оршиж байгаа асуудлуудыг шийдвэрлэхэд зохих нөлөө үзүүлжээ.

1957 онд Монголд болсон эрдэм шинжилгээний хурлаар шинэ монгол үсгийн зөв бичгийн дүрэмд засвар оруулах буюу цагаан толгой нэмэх нь урт удаан хугацааны асуудал байсан юм. Өвөр монголын ард түмэн болон сурагчид шинэ монгол үсгийг үргэлжлүүлэн сурч хэрэглэхэд засвар оруулсан “Шинэ монгол үсгийн цагаан толгой” болон “Зөв бичгийн дүрэм”-ийг дахин сурах болохоор багш сурагчдын ачаалал ихсэх нь лавтай. Тухайн үеийн багш нар хичээл заахын хамт бас шинэ монгол үсгийг суралцах хэрэгтэй, зарим бага сургууль нь шинэ монгол үсэг, хуучин монгол үсэг, хятад хэл, хятад хэлний галиг үсэг дөрвөн зүйлийн хэл бичгийн хичээл үзэж байв. Бусад сургуулиуд шинэ монгол үсгийг нэг жил сураад хичээлийг шинэ монгол үсгээр зааж эхэлсэн нь багш сурагчдын ихэнх ачаалалд орж, сургалтын чанар илт буурчээ. Энэ нь Өвөр монгол дахь шинэ монгол үсгийн өөрчлөлт ард олны соёлын түвшин болон боловсролын түвшинг дээшлүүлэх гэсэн үйл ажиллагаатай нийцээгүй юм. Үүнээс гадна монгол үндэстний хэдэн зуун жилийн түүх, соёл зонхилох хуучин монгол үсгээр тэмдэглэж хадгалсаар ирсэн болохоор хуучин монгол үсгээ суралцаж үндэстний соёлоо уламжилж хөгжүүлэх ёстой гэж үзэж байсан байна.

Иймээс 1958 оны 3 дугаар сард ӨМӨЗО-ны Ардын комиссоос шинэ монгол үсгийн өөрчлөлтийн хөдөлгөөнийг зогсоосныг зарлажээ.

Дүгнэлт

ӨМӨЗО байгуулагдсаны дараа ХКН-ын Төв Хорооноос шинэ монгол үсгийн өөрчлөлтийн төрийн бодлогыг хэрэгжүүлэхээр ӨМӨЗО дахь олон түмний соёл, аж ахуйн хөгжлийг дээшлүүлэх гэсэн шаардлагаас үүдэн 1955 оноос шинэ монгол

⁵² “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хэл шинжлэлийн доктор Ринченээс Дундад улсын шинжлэх ухааны хорооны дарга Гуо Мо Жод илгээсэн захиа”, 1957 оны 1 дүгээр сарын 2, ӨМӨЗО-ны архивын газар, 243-1-339, 98-101.

үсгийн өөрчлөлтийг өрнүүлсэн. ӨМӨЗО-ны шинэ монгол үсгийн өөрчлөлт нь Өвөр монголын үндэстний соёлын хөгжлийн нэгэн хэсэг байсан төдийгүй ээдрээтэй замыг туулсан. ӨМӨЗО-ны Ардын комиссоос шинэ монгол үсгийн өөрчлөлтийн явцад ямагт болгоомжтой арга хэмжээ авч, шинэ монгол үсгийг хэрэгжүүлж байх явцад ч гэсэн хуучин монгол үсгээ таягдан хаяагүй юм. Иймээс Өвөр монголд үсэг бичгийн өөрчлөлт хийсэн ч хуучин монгол үсгээ дахин хэрэглэхэд тийм хэцүү бэрх байдалд орсонгүй.

Өвөр монгол дахь үсэг бичгийн өөрчлөлтөөр Монголд шинэ монгол үсгийн чадвартай багш нарыг сургасан нь БНХАУ, БНМАУ хоёр улсын соёл, боловсролын харилцааг ахиулсан бөгөөд 1955-1964 онд БНХАУ-аас Монголд туслах ажилтан илгээж мөн шинэ ба хуучин монгол үсэг, хятад үсэгт мэргэшсэн орчуулагч нарыг томилсон нь дэмжлэг болсны хамт Мао Зе Дуны өгүүллүүдийг хэвлэсэн зэргээр хоёр улсын харилцаа бүх талаар хөгжиж байлаа.

1956 онд ЗХУ, Польш, Унгарт цэргээ оруулсны дараа БНХАУ-аас Зүүн Европын явдалд эхлэн оролцож, БНХАУ-ын ХКН-ын социалист систем дэх байр суурь ихээхэн өргөжив. Иймд БНХАУ-ын ХКН-аас дотоод болон гадаад дахь төрийн бодлогоо чангатгаснаас гадна улсын дотоод дахь цөөн тоот үндэстнүүдийн үсэг бичгийн өөрчлөлтийг шийдэмгий хийж, латин галигт суурилсан “Хятад хэлний галиг үсэг”-ийг хэрэгжүүлж эхэлснээр ӨМӨЗО-ны Засгийн газраас найман жилийн бэлтгэл болон гурван жилийн хэрэгжүүлэлттэй нийт 11 жилийг туулсан шинэ монгол үсгийн өөрчлөлтөө зогсоожээ.

Хэдийгээр ЗХУ, БНМАУ, БНХАУ тухайн үеийн үзэл суртлын нэг эгнээн дэх ах дүү улс боловч зарим асуудалд анхаарал хандуулаагүй нь харагддаг. Жишээлбэл, Өвөр монголд шинэ монгол үсгийг нэвтрүүлэх явцад олон бэрхшээлтэй асуудал байсан, гэвч Зөвлөлт болон Монголын талаас асуудлыг нь зааж гарган анхаарал хандуулаагүй учраас Өвөр монгол дахь шинэ монгол үсгийн өөрчлөлтөд оршиж байгаа асуудлыг шийдвэрлэх талаар ахиц гараагүй юм.

Үүнээс гадна тус өгүүлэлд хоёр асуудлыг онцлон тайлбарлав.

Нэгдүгээрт, доктор Б.Ринчений захиа Өвөр монгол дахь шинэ монгол үсгийн өөрчлөлт төгссөний гол шалтгаан болох эсэх тухай асуудал болно. Доктор Б.Ринченээс Мао Зе Дун болон Улаанхүүд илгээсэн захидал нь Өвөр монгол дахь шинэ монгол үсгийн өөрчлөлт төгссөний чухал шалтгаан гэж Монголын зарим эрдэмтэд үздэг. Энэ нь захидлын агуулга болон нөлөөг илт давуулж үзсэний илрэл. Зохиогчоос тус захиаг судлаад Монгол улс дахь шинэ монгол үсгийн өөрчлөлтөд оршиж байгаа асуудал болон Өвөр монгол дахь шинэ монгол үсгийн өөрчлөлтийг зогсоохыг санаачилсан нь үнэн юм. Гэвч 1958 онд ӨМӨЗО-ны Ардын комиссоос шинэ монгол үсгийн өөрчлөлтийг төгсгөсөн нь энэхүү захианы нөлөө биш харин улсын дотоод дахь төрийн бодлогоос шалтгаалсан болох нь дээр өгүүлсэн агуулгаас харагдана.

Хоёрдугаарт, Өвөр монгол дахь шинэ монгол үсгийн өөрчлөлт зогссон нь БНХАУ, БНМАУ хоёр улсын харилцаа муудсантай холбоотой эсэх тухай асуудал болно. Хятад, Монгол хоёр улсын харилцаа нь ЗХУ-ын нөлөөнөөс болж 1960 оноос эхэлж муудсан. Гэвч 1958 оны 3 дугаар сард Өвөр монгол дахь шинэ монгол үсгийн өөрчлөлтийг зогсоосон нь хоёр улсын харилцаанд улс төрийн нөлөө тийм их холбоо байхгүй гэдгийг нотолж байгаа болно.

Abstract

From 1947 to 1958, in order to generally improve the cultural level of the people in ethnic minority areas and to meet the needs of rapid economic development, the Inner Mongolia Autonomous Region carried out a literacy campaign at the beginning of its establishment. In the context of the central government's ethnic policies and nationwide character reforms, Inner Mongolia announced in 1955 that it would officially implement the use of the new Mongolian script. The former Soviet Union and the People's Republic of Mongolia also once supported the reform of the new Mongolian script in the Inner Mongolia Autonomous Region. The Inner Mongolia Autonomous Region has made some achievements in the reform of the new Mongolian script, but there are also many problems. Later, due to the implementation of the "Hanyu Pinyin" character reform based on the Latin alphabet and other external factors, the Inner Mongolia Autonomous Region stopped the new Mongolian character reform movement in 1958. The new Mongolian script reform movement in the Inner Mongolia Autonomous Region was an attempt by the government to improve the cultural level of minority areas in the early days of the People's Republic of China.